

Монгол хэл, аялгуутны үндсэн өнгө заасан өвөрмөц үгс

Мягмаржавын АВИРМЭД*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын ЭША, доктор (Ph.D)

Агуулгын товч:

Аливаа нэг үндэстний хэлэнд хэрэглэгддэг үндсэн өнгөний нэрс гол төлөв тухайн ард түмний хэл, соёлын нийтлэг шинжийг агуулж байдаг. Өнгө, тоо, хэлбэр дүрс зэргийн нэрийг хэл шинжлэлийн талаас судлах нь тухайн нэг үндэстний соёл, сэтгэлгээний хөгжил, ертөнцийн аливаа юмсыг хэрхэн таньсан бэ гэдгийг мэдэхэд чухал үүрэгтэй.

Бид тус өгүүлэлд өнөө үед монгол хэлээр ярилцагч ард түмний хэлэн дэх үндсэн өнгөний нэрийг судалсан бөгөөд Монгол улс, Өвөр Монголын аймгууд, Хөхнуур, Шинжаан, Халимаг, Буриад зэрэг адил бус газар оршин суудаг 384 хүнээс цахим судалгаа авч үзэхэд, зарим үндсэн өнгө нь ижил, зарим нь ялгаатай хэлэгдэж байгааг ажиглав.

Монгол хэлний үндсэн өнгөний нэрийг дотор нь “нийтлэг хэлэгддэг үндсэн өнгөний нэр”, “өвөрмөц шинжтэй үндсэн өнгөний нэр” хэмээн ангилж болох бөгөөд судалгааны явцад хамгийн их өндөр давтамжтай илэрсэн “өвөрмөц хэлэгддэг өнгөний нэр”-ийг утга, соёлын талаас судлан өгүүлэв.

Түлхүүр үг: Монгол хэлтэн, үндсэн өнгөний нэр, өвөрмөц шинжтэй өнгөний нэр, өнгөний нэр, өнгө заасан үг.

1. Удиртгал

“Үндсэн өнгөний нэр” (basic color name) гэх ойлголт нь аль шинжлэх ухааны үүднээс судалж байгаагаас хамаараад янз бүр. Жишээлбэл физикийн шинжлэх ухааны үүднээс “солонгын долоон өнгө”-ийг үндсэн өнгө хэмээн нэрлэдэг. Үүнд бидний сайн мэдэх “хар”, “цагаан”, “саарал”, “хүрэн”, зэрэг өнгө багтаагүй байгааг төдийлөн хүмүүс анзаардаггүй. Харин хэл шинжлэлийн талаас судлахдаа дээрх өнгөнүүдийг багтааж, “үндсэн өнгөний нэр” хэмээн тодорхойлдог.

“Эрдэмтэн Бэрлин, Кэй нар дэлхийн ихэнх хэлэнд гол төлөв “үндсэн өнгөний нэр”-нд 11 өнгө багтдаг бөгөөд эдгээр үгийн бүтэц нь энгийн, дан

* © М.Авирмэд 2024
Email: avirmed@mas.ac.mn

үгээс бүтсэн, хэрэглэгдэх давтамж өндөр байхаас гадна өнгөний хүрээний зааг нь харилцан адилгүй, эзлэх байр суурь нь ч харилцан адилгүй байдаг гээд нийт 7 үе шаттайгаар бүрэлджээ” (王寅著, 2018: 105-107) хэмээн үзсэн байна. Энэхүү судалгаанд 98 орны хэлийг хамруулан судалсан бөгөөд судалгаанд хамруулсан улс орнууд хэчнээн үндсэн өнгөний нэртэй болохыг доорх хүснэгтээс үзнэ үү.

WHITE BLACK	Stage I
9 languages:	7 New Guinea 1 Congo 1 South India
WHITE BLACK RED	Stage II
21 languages:	2 Amerindian 16 African 1 Pacific 1 Australian Aboriginal 1 South India
WHITE BLACK RED GREEN	Stage IIIa
8 languages:	6 African 1 Philippine 1 New Guinea
WHITE BLACK RED YELLOW	Stage IIIb
9 languages:	2 Australian Aboriginal 1 Philippine 3 Polynesian 1 Greek (Homeric) 2 African
WHITE BLACK RED GREEN YELLOW	Stage IV
18 languages:	12 Amerindian 1 Sumatra 4 African 1 Eskimo
WHITE BLACK RED GREEN YELLOW BLUE	Stage V
8 languages:	5 African 1 Chinese 1 Philippine 1 South India
WHITE BLACK RED GREEN YELLOW BLUE BROWN	Stage VI
5 languages:	2 African 1 Sumatra 1 South India 1 Amerindian
COMPLETE ARRAY OF COLOURS	Stage VII
20 languages:	1 Arabic 2 Malayan 6 European 1 Chinese 1 Indian 2 African 1 Hebrew 1 Japanese 1 Korean 2 South East Asian 1 Amerindian 1 Philippine

хүснэгт-1

Эх сурвалж: http://www.putlearningfirst.com/language/research/colour_words.html

Монгол хэл, аялгуунуудад зарим өнгө нь адил нэрээр нэрлэгддэг боловч зарим нь өөр өөр нэртэй байна. Үүнийг ажиглавал, Монголчуудын дунд эртнээс нийтлэг хэлэгдэж, нийтлэг танигдсан өнгөний нэрс нь адил, харин өдөр тутамд нүдэнд үзэгдээд байдаггүй учраас тогтсон нэршилгүй (өөр өнгөний айд хамаарагдаж) байснаа эд бодисын хэрэглээ нэмэгдэхийн хэрээр бидний амьдралд тогтмол харагдах болсон өнгө нь өөр өөр газарт харилцан адилгүй нэрлэгддэг болох нь судалгааны явцад анзаарагдаж байна. Мөн ч энэ нь оршин буй газар орны байр байц, соёлын ялгаа зэрэгтэй уялдаатай юм.

Эдгээр адилгүй хэлэгддэг өнгөний нэрсийг дээр дурдсан Бэрлин, Кэй нарын тодорхойлолтын дагуу “үндсэн өнгө” гэж үзэж байна. Өнөөгийн монгол хэлтнүүдийн ярианд хэрэглэгддэг өнгөний нэрсийг судалгааны үр дүнд түшиглэн үзүүлэв.

1. Судалгааны арга

Энэхүү судалгаагаар дэлхийн олон хэлнүүдэд үндсэн өнгөний нэрээр хэрэглэгддэг 13 өөр өнгийг сонгон авч, өнөө үед монгол хэлийг хэрэглэж байгаа 14 өөр газар орны хүмүүсээр нэрлүүлсэн. Ингээд нийтлэг нэрлэлт болон ялгаатай нэрлэлтээр нь ангилж, тухайн бүс нутагт аль хэдийн хэвшиж тогтсон өвөрмөц

нэрлэлтийг сонгон авч, үгийн утга, бүтэц, гарал зүй, болон соёл хэл шинжлэлийн талаас нь судалсан болно. Ингэхдээ асуулга анкетын арга, байдлыг тодорхойлох арга, түүхэн харьцууллын арга, танихуйн хэл шинжлэлийн айжуулах арга зэргийг ашигласан.

Судалгаанд хэрэглэсэн өнгө нэрлэх зураг

Эдгээр 13 өнгийг сонгосны учир нь өөр өөр хэлнүүдэд тус тусдаа ай болж чаддаг өнгөнүүд бөгөөд монгол хэлтнүүд эдгээр өнгийг хэрхэн нэрлэж байгааг судлах зорилготой юм.



Зураг-1

Судалгаанаас гарсан үр дүнгийн хүснэгт

Дээрх “зураг-1”-ийг Монгол үндэстэн амьдардаг 14 өөр газар орныг хүмүүсээр нэрлүүлж, үр дүнг ерөнхийлөн дүгнэж, доорх хүснэгтэд нэгтгэсэн билээ. Нэг бүс нутагт байгаа хүмүүс ч нэг өнгийг өөр өөрөөр нэрлэх нь элбэг тохиолдож байгаа бөгөөд олон өөрөөр нэрлэгдэж буй өнгийн нэрийг нэг нүдэнд идэвхтэй хэрэглэгдэх дарааллаар нь жагсааж оруулав.

Монгол улс												
хар	Цагаан	Саарал	Улаан	Шар	Улбар шар	Ногоон	Хөх	цэнхэр	бор	Хүрэн	ягаан	Нил ягаан, Чернилэн ягаан, Үзмэн ягаан
Ордос												
хар	цагаан	Саарал Бор хөх	Улаан	Шар	Улбар шар\ гал шар	Ногоон	хөх	Хайлан Цэнхэр Хөх	бор	Хүрэн	Хондон Ягаан Жигэн	Жигэн Хундан
Шилийн гол												
хар	цагаан	Бор саарал хөх үнсэн	Улаан	Шар	Улбар шар\ гал шар\	Ногоон	хөх	цэнхэр	бор	Хүрэн	ягаан	Гүн ягаан\ хөх ягаан
Баяннуур												

хар	цагаан	Бор хөх саарал	Улаан	Шар	Гандуу шар, гал шар, болсон шар	Ногоон	хөх	Цэнхэр	Бор	хүрэн	Ягаан	Пэнчин
Хянган аймаг												
хар	цагаан	Үнсэн Хуйшаа хуншаа	Улаан	Шар	Гүн шар Болсон шар	Ногоон	хөх	цэнхэр	Бор	Улаан , бор, хүрэн	ягаан	Хашин, хашин бор, Хундан
Улаанхад												
хар	цагаан	Саарал Хөх Хүрэн Үнсэн хуйшаа	Улаан	Шар	Гүн шар, Болсон шар	Ногоон	хөх	цэнхэр	Бор	Бор, хүрэн	Хундан, ягаан	Чөөсөн, Нүүхөө
Жирэм												
хар	цагаан	Хүрэн, Үнсэн, Цайвар, Саарал, үнсэн	Улаан	Шар	Гүн шар, Болсон шар	Ногоон	хөх	Цэнхэр, Ягаан, яадаан	Бор	Бор, хүрэн	Хундан, ягаан	Бор, Хүрэн, Нүүхөө, Ягаан, Хундан
Алшаа												
хар	цагаан	Бор, Саарал, үнсэн	Улаан	Шар	Улаан шар, гал шар	Ногоон	хөх	цэнхэр	Бор	бор, хүрэн, гутан	Ягаан Уушги Хондон	Сосон,
Шинжаан												
хар	цагаан	Бор, Үнсэн, хохолойргоно	Улаан	Шар	Улаан шар, гүн шар	Ногоон	хөх	цэнхэр	Бор, Хүрэн	хүрэн	Уушги, Сосон,	Зандан, Уушги, Сосон,
Хөхнуур												
хар	цагаан	Бор, үнсэн	Улаан	Шар	Хонгор, Шар улаан, ангир	Ногоон	Хөх	Цэнхэр	Бор, Хүрэн	Хүрэн	Сосон, Ягаан	Сосон, Ягаан
Барга												
хар	цагаан	Бор, Саарал, үнсэн	Улаан	Шар	Улбар шар, Болсон шар	Ногоон	хөх	цэнхэр	Бор, Хүрэн	Хүрэн	Ягаан	Ягаан
ОХУ-ын Буриад улс												
хар	цагаан	бор	Улаан	Шар	Шар улаан, Улбар шар	Ногоон	Хөх	цэнхэр	Хүрэн	Хүрэн	Ягаан	Ягаан хөх, Ягаан, Улаан хөх
ОХУ-ын Халимаг улс												
хар	цагаан	Бор	Улаан	Шар	Ошгв, Улбар шар, Хоо	Ногоон	Хөх	цэнхэр	Хүрэн	Хүрэн	Уушги	Чүүкл

Хүснэгт-2

Нэг. Монгол улсад хэлэгддэг үндсэн өнгөний нэрийн өвөрмөц шинж

Энэхүү судалгаанд оролцсон Монгол улсын хүмүүсийн өнгийг нэрлэх явц нь харьцангуй тогтворжсон байх бөгөөд бусад монгол хэлтнээс ялгарах онцлог бага зэрэг бий. Тухайлбал: хөх ба цэнхэр өнгийг хольж солин нэрлэх нь элбэг тохиолдож байна. “Хөх” өнгийг “монгол хэлний гучтын тайлбар толь”-д: “солонгын долоон өнгийг цэнхэр болон ягааны дунд байх 435-470 нанометр долгионы урттай өнгө” (Одонтөр, Ш., Баттөгс, М. 2013:801) хэмээсэн бол “Цэнхэр өнгө”-ийг “монгол хэлний гучтын тайлбар толь”-д: солонгын долоон өнгөний ногоон болон хөх өнгөний дунд байх 470-495 нанометр долгионы урттай өнгө” (Одонтөр, Ш., Баттөгс, М. 2013), “монгол хэлний товч тайлбар толь”-д: “цайвгар хөх өнгө” (Цэвэл, 1966:806) хэмээн тэмдэглэжээ.

Монгол улсын монгол хэлтнүүд “цэнхэр өнгө” гэх нэрлэлт нь “хөх өнгө”-өөс давамгай хэрэглэгдэж байгаа бөгөөд үүний шалтгаан нь: Монгол улсын яруу

найрагчид “тэнгэр”, “гол нуур”, уул ус зэргийг магтан дуулахдаа “увсын цэнхэр хязгаар”, “цэнхэр тэнгэрийн орон”, “цэнхэр хангай нутаг”, “цэнхэртэн харагдах уулс” гэх мэт гол төлөв “цэнхэр өнгө”-өөр илэрхийлдэгтэй холбоотой байж мэднэ.

“Мөн англи зэрэг хэлэнд pink, purple зэргээр хоёр өнгөний айд багтдаг өнгийг “ягаан”, “нил ягаан” (үзмэн ягаан, чернилэн ягаан) гэж ялгах ба угтаа “ягаан” гэх нэг өнгөний айд багтаж байна.

Монгол улсын судалгаанд оролцогчдоор #FC0FC1 (html color code)¹ кодтой “ягаан өнгө”-ийг нэрлүүлэхэд: 50 хүн “ягаан өнгө”-ийн айд хамааруулан нэрлэсэн бөгөөд өөр нэрлэлт илрээгүй байгаагаас үзвэл тус “ягаан” гэх өнгө заасан нэр тогтвортой хэрэглэгддэг болсон байна.

Монгол улсын судалгаанд оролцогчдоор #9B27B0 кодтой “ягаан өнгө” -ийг нэрлүүлэхэд: 22 хүн “чернилэн ягаан”, 9 хүн “үзмэн ягаан”, 6 хүн “нил ягаан” хэмээн нийт 48 хүн “ягаан өнгө”-ийн айд хамааруулж, 1 хүн “нил өнгө”, 1 хүн “хөх өнгө” хэмээн хариулсан байна. Үүнээс үзвэл ягаан өнгө харилцан адилгүй “чернилэн”, “үзмэн”, “нил” гэх гурван өөр тодотгол авч нэг өнгийг зааж байна.

Монгол улсад “чернил” хэмээх орос бэхийг үзэгтээ соруулж, бичиг үйлддэг байсан учраас чернилийн ягаан өнгийн тухай гүн гүнзгийн танилтай болж, тийм өнгийг “чернилэн өнгө” гэвэл бүгд андахгүй мэддэг болсон байна. Урьд өмнө нь ийм өнгийг эд юмны өнгөнөөс төдийлөн харж байгаагүй байтал тус өнгө бараа материал, эдлэл хэрэглэлийн өнгөнд арвин хэрэглэгдэх болоход оновчтой нэрлэх шаардлага зүй ёсоор гарчээ. Ингээд тухайн үед хэрэглэгдэж байгаа тийм өнгөтэй зүйлсийн дотроос хамгийн их хүмүүсийн мэддэг зүйлийн өнгөөр тодотгон уг өнгийг хэлбэл бүх хүн ойлгодог ажээ. Ингэж бүтсэн өнгөний нэр нь эхэндээ хоршоо үгээр хэлэгдэж байснаа алсдаа уг өнгөний нэр болох нь элбэг. Жишээ нь: Зүүн хойд Кавказын Khinalug хэлэнд тус өнгө “чернил” гэх дан үгээр өнгө заан нэрлэгдсэн байна.²

“нил ягаан” гэх тодотголд байгаа “нил” хэмээх үг нь санскрит хэлнээ “nīla-хөх цэнхэр” (Сүхбаатар, 1997:147) хэмээн тэмдэглэсэн байна. Мөн нил мод гэж байх бөгөөд “Нил (Violaceae) нь дэлбэ, дохиур цоморлогийн навчинцар тус бүр 5 годой, богино уутархуу дэлбийн доод илтсээс үүсэлтэй. Хонгорцог гурван хавтсаар нээгддэг. Монгол оронд 16 зүйлийн нил бүртгэгджээ” (Суран, Д ба бусад 2012: 221). Энэхүү “нил” гэх үг нь монгол хэлэнд улаан, хөх хоёрын холилдсон өнгийг нэрлэхэд оролцож, “нил ягаан” хэмээн хэлэгдэж хэвшсэн байна.

Эдүгээ Энэтхэгийн олон хэлэнд “нил” гэх үг нь “хөх” өнгийг зааж хэрэглэгдсээр байна.³

Хоёр. Өвөрмонголд хэлэгддэг өвөрмөц шинжтэй үндсэн өнгөний нэр Жигэн өнгө (жигээн өнгө)

Ордос хотын судалгаанд оролцогчдоор #9B27B0 кодтой “нил ягаан өнгө”

¹ Html color code буюу html өнгөний кодоор интэрнет ашиглан ямар өнгө болохыг мэдэж болно.

² <https://www.omniglot.com/language/colours/>

³ <https://www.omniglot.com/language/colours/>

-ийг нэрлүүлэхэд 21 хүн “жигэн өнгө”, 3 хүн “хундан өнгө”, 2 хүн “ягаан өнгө”, 1 хүн “бөгөөн өнгө”, 1 хүн “цайвар өнгө” зэргээр хариулсан байна.

Ордос хотын судалгаанд оролцогчдоор #9B27B0 кодтой “ягаан өнгө”-ийг нэрлүүлэхэд 20 хүн “хондон өнгө” (хундан), 6 хүн “ягаан өнгө”, 2 хүн “жигэн өнгө”, 1 хүн “мойлын өнгө” хэмээн хариулсан бөгөөд их төлөв “хундан өнгө” хэмээх өнгөний ай болон хэвшсэн байна. Ц. Норжин нар найруулсан: “Монголын хэлний толь”-д: “хундан- ① цайвар улаан буюу ягаан өнгө, ② хонины цул цагаан зүсэм” (Норжин, 1999:1450) хэмээжээ.

Дээрх хоёр өнгийг харьцуулан харвал улаан ба цагаан холилдсон өнгийг “хундан өнгө”, хөх ба улаан холилдсон өнгийг “жигэн өнгө” хэмээн нэрлэж байгаагаас үзвэл тус тусдаа өнгөний ай болж байна. Монгол улсад хамгийн их хэрэглэгдэж байгаа “ягаан” гэх өнгө заасан үг Ордост төдийлөн хэрэглэгдэхгүй байгаа нь судалгаанд оролцсон хүмүүсийн хариултаас харагдаж байна.

“Mongxol I iüi toli bičig”-т ягаан гэх өнгөний нэр тэмдэглэгдээгүй ч ягаан гэх үгийн нэгэн хувилбар байж мэдэх “Jiqiyin” гэх үг тохиолдож байна. Энэ нь “küreng, boru -紫曰 只希因” (Мандах, 1995:593) хэмээн тус тольд тэмдэглэжээ. Өвөр Монголын зарим нутагт үзмэн ягаан, хүрэн ягаан өнгийг “хашин бор” өнгө гэж нэрлэдэг. Ийм учраас Ордост хэрэглэж буй “жигэн” гэх үг нь эрт үед монгол хэлэнд хэрэглэгдэж байжээ. Мөн тус үгийн анхдагч язгуур нь “жирэмсэн”, “жич”, “жишээ” зэргээр хоёр гэх утгыг заадаг үгстэй нэг язгууртай байх боломжтой. Учир нь “нил ягаан” өнгө нь улаан, хөх хоёр өнгөнөөс бүтдэг тул “хоёр” гэх утгыг илтгэсэн “жи” язгууртай үг байж магадгүй.

Хайлан өнгө

Ордос хотын судалгаанд оролцогчдоор “цэнхэр өнгө”-ийг нэрлүүлэхэд: 14 хүн “цэнхэр өнгө”, 8 хүн “хайлан өнгө”, 9 хүн “цэнхэр хөх”, “хайлан хөх” зэргээр “хөх өнгө”-ийн айд хамааруулж, 1 хүн “цэгээн”, 1 хүн “бөгөөн” өнгө хэмээн хариулсан байна. “хайлан” гэх үгийг “Монгол хэлний харь үгийн толь”-д: “далайн хөх: цэнхэр хөх өнгийн нарийн бөс барааны ерөнхий нэр” (Сүхбаатар, 1997:193) хэмээжээ. Энэ үг нь хятад хэлний 《海藍》(hailan) хэмээх үгээс гаралтай бөгөөд хөх өнгийн цайвар шинж буюу дээрх судалгаанаас ажиглавал “цэнхэр” “өнгөтэй утга дүйж байна. “Хайлан” гэх энэхүү нэршил бусад газрын судалгаанд оролцогчдоос илрэхгүй байгаа бөгөөд бидний судалгаанаас үзэхэд зөвхөн Ордосын нутгийн аялгуунд хэлэгдэж хэвшжээ.

Яадаан өнгө

Хянган аймгийн судалгаанд оролцогчдоор “цэнхэр өнгө”-ийг нэрлүүлэхэд 5 хүн “цэнхэр өнгө”, 3 хүн “яадаан” өнгө хэмээсэн бол Жирэм аймгийн оролцогчдоор “цэнхэр өнгө”-ийг нэрлүүлэхэд 13 хүн цэнхэр, 8 хүн “хөх өнгө”, 7 хүн “ягаан өнгө”, 4 хүн “яадаан өнгө”, 1 хүн “хүрэн өнгө” гэх зэргээр хариулсан байна. Бусад байршлын судалгаанд оролцогчдоос ялгаатай нь гэвэл “ягаан өнгө”, “яадаан өнгө” гэх нэршил их илэрч байгаа нь өвөрмөц юм.

Тус судалгаанд оролцогчид “яадаан гэдэг нь хятад үг байж магадгүй”

хэмээсэн бөгөөд бидний үзэхээр хятад хэлний “鸭蛋色” (yadanse) буюу “нугасны өндөгний өнгө” гэх өнгө заасан үгээс үүссэн гэж үзэж байна. Нугасны өндөгний хальс цэнхэр туяатай харагддаг учир тус өнгө “цэнхэр” гэх үгийн үүргээр Жирэм аймгийн нутгийн аялгуунд хэлэгддэг болсон бололтой. Харин “ягаан” гэх хэллэг нь хожуу тус нутагт хэлэгддэг болсон буюу залуучууд (залуучууд ягаан, настай хүмүүс яадаан гэж хэлдэг) бусад зэргэлдээ монгол хэл аялгуутнуудаас эсвэл бичигт тэмдэглэгдсэн “ягаан” гэх үгийг өөрсдөө хэлдэггүй тул “яадаан”-тай адил үг (дуудлага ойролцоо) гэж бодсоны үндсэн дээр ийнхүү “цэнхэр өнгө”-ийг заан нэрлэсэн бололтой.

“Ягаан” гэх үгийг “Монгол хэлний товч тайлбар толь”-д: “цайвгар улаан өнгө; хуа ягаан; ягаан хүрэн, үзэм ягаан...” (Цэвэл, 1966:900), “Монгол үгсийн язгуурын толь”-д: “уахан- 分色; “улаан цагаан нийлсэн өнгө, цайвар ч гэдэг” (Сэцэнцогт, 1988:2466) хэмээн тайлбарлажээ. Эдгээр толь бичгийн тайлбараас үзвэл “ягаан” гэх үг “цэнхэр өнгө”-ийг заан нэрлэхэд төдийлөн хамааралгүй гэдэг нь харагдаж байна.

Пэнчин өнгө

Баяннуур аймгийн судалгаанд оролцогчдоор #9B27B0 өнгөний кодтой “нил ягаан өнгө” -ийг нэрлүүлэхэд: 15 хүн “ягаан өнгө”, 1 хүн “хундан өнгө” 1 хүн “пэнчин өнгө” хэмээн хариулсан байна.

Баяннуур аймгийн судалгаанд оролцогчдоор #9B27B0 кодтой “ягаан өнгө” -ийг нэрлүүлэхэд: 7 хүн “пэнчин өнгө”, 5 хүн “хүрэн өнгө”, 1 хүн “бор ягаан” өнгө, 1 хүн “жигэн өнгө” хэмээн хариулсан байна.

Баяннуур аймгийн судалгаанд оролцогчдын хариултыг бидэнд мэдэгдэж байгаагаар ажиглахад: #9B27B0 кодтой “ягаан өнгө” -ийг “ягаан”, #9B27B0 кодтой “нил ягаан өнгө”-ийг “пэнчин өнгө” хэмээн 2 ай болон хуваан хэлж хэвшсэн байна. “Пэнчин” гэх үг нь хятад хэлний 粉色, 青色 гэх өнгөний нэрээс хоршин бүтсэн гэж бид үзэж байна.

Хашин өнгө (хашин бор өнгө)

Улаанхадын судалгаанд оролцогчдоор #9B27B0 кодтой “ягаан өнгө”-ийг нэрлүүлэхэд: 19 хүн “хундан өнгө”, 19 хүн “ягаан өнгө”, 1 хүн “цайвар өнгө” хэмээсэн бөгөөд #9B27B0 кодтой “нил ягаан өнгө”-ийг нэрлүүлэхэд 9 хүн “хашин бор”, “чээсэн бор” зэргээр “бор өнгө”-ийн айд, 4 хүн “хундан өнгө”, 3 хүн “улгай”, 3 хүн “ягаан”, 3 хүн “индүү”, 2 хүн “сөдөн өнгө” зэргээр харилцан адилгүй хариулсан байгаагаас үзвэл тус айн нэрлэлт Улаанхад аймгийн өөр өөр газарт харилцан адилгүй нэрлэгддэг нь ажиглагдаж байна.

Жирэм аймгийн судалгаанд оролцогчдоор #9B27B0 кодтой “ягаан өнгө” (粉色) -ийг нэрлүүлэхэд: 25 хүн “хундан өнгө”, 6 хүн “ягаан өнгө”, 1 хүн “сүен өнгө”, #9B27B0 кодтой “нил ягаан өнгө”-ийг нэрлүүлэхэд: 12 хүн “хашин бор” өнгө, 6 хүн “хүрэн өнгө”-ийн айд, 4 хүн “хундан өнгө”, 1 хүн “нүүхөө өнгө”, 1 хүн “луушаа өнгө”, 1 хүн “ягаан өнгө” хэмээн хариулсан байна.

Энэхүү судалгаанаас ажиглахад Өвөрмонголын зүүн аймгууд “нил ягаан өнгө”-ийг “хашин өнгө”, “хашин бор өнгө”, “бор өнгө” гэхээс гадна “чээсэн

өнгө” гэж хэлдэг. Хятадын “茄子”(qiezi) гэх ногоог Монголчууд “хаш” хэмээн нэрлэдэг бөгөөд тус газрын Монголчууд ногоо хэрэглэх нь элбэг. Тэд мал гэвэл зөвхөн үхрийг хэлж байна гэж ойлгодог бөгөөд бусад малыг үржүүлдэггүй. Иймээс тариалангийн соёл нь өнгө заасан үгэнд мөн тусгалаа олсон байна.

Хундан өнгө

Монгол улсын зарим газар, Өвөрмонголын нэлээд газар ягаан өнгийг хундан өнгө хэмээн нэрлэдэг. Өвөрмонголын зарим газар мөн Хөхнуур, Халимаг гэх зэрэг газарт “ягаан” гэх үгийг аман ярианд хэрэглэдэггүй. Л.Болд нарын бичсэн “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д: 1. “... нүүр толгой болон биед өөр өнгө холилдоогүй цул цагаан хонины зүсэм: хундан цагаан хонь (цул цагаан зүсмийн хонь)...” гэсэн ба 2. өөр өнгөтэй холилдоогүй цулгүй цайвар өнгө: хундан шар (цулгүй шар өнгө), хундан улаан (ягаан улаан, цайвар улаан)” (Болд,2008:2693) хэмээн тайлбарлажээ.

Гурав. Ойрад Монголчуудын ярианд хэрэглэгддэг өвөрмөц шинжтэй үндсэн өнгөний нэрс

Хонгор өнгө

Хөхнуурын Монголчуудын дунд улбар шар өнгийн зургийг үзүүлэн нэрлүүлэхэд 47 хүнээс 11 хүн “хонгор өнгө”, 8 хүн “шар улаан” өнгө, 7 хүн “улбар шар” өнгө, бусад нь “ангир өнгө”, “шарга өнгө”, “жүржин өнгө” гэх мэтээр хариулсан байна.

“Хорин наймт тайлбар толь”-д: “морины шаравтар зүсмийг хонгор морь хэмээмүй” (Намжилмаа, 1988:942) гэсэн бол Ү. Мандахын эмхэтгэсэн “Монгол И Иүй толь бичиг” -т шар өнгийг “sir-a basa qongyog gen-e” (Мандах,1995:593) хэмээсэн нь эрт үед хонгор гэх өнгө заасан үг өргөн утгаар хэрэглэгдэж байгаад хожуу зөвхөн морины зүс заах болон хүрээ хэмжээ нь явцуурсан тал ажиглагдаж байна. Харин Хөхнуурын Ойрадуудын дунд идэвхтэй хэлэгдсээр иржээ.

Монгол улсад тус өнгийг “улбар шар”, Өвөрмонголд “улбар шар”, “болсон шар”, “гал шар”, “шарангуй” гэх мэтээр нэрлэж, гол төлөв шар өнгөний айд хамааруулж байхад зарим хэсэг нь “улбар өнгө” гэж нэрлэгдээс үзвэл “улаан” өнгөний айд ч мөн багтаах шинжтэй болж, айн хувьд тогтворгүй хэлэгдэж байна. Ингэснээрээ үндсэн өнгөний айд бие даасан өнгө болж чадахгүй байгаа ч Хөхнуурын Монголчуудын зарим хэсэгт “хонгор өнгө” гэж нэг үгээр нэрлэгдэж байгаагаас ажвал бие даасан шинжтэй “үндсэн өнгөний нэр” болж чадаж байна.

Энэхүү өнгийг дэлхийн олон улс оронд “оранж өнгө” хэмээн нэрлэж байгаа бөгөөд “оранж” хэмээх нэрлэлт нь улам бүр даяарших хандлагатай болж байна. Ийм учраас өөрсдийн хэрэглэж нэрлэдэг уламжлалт нэршлээ хэвээр нь хадгалж үлдэх боломжийг мөн эрэлхийлэх нь зүйтэй юм. Өнгөний нэрийн хувьд дан үгээс бүтсэн өнгө нь нэлээд тогтвортой байх хандлагатай байхад хоршоо үгээр хэлэгддэг “улбар шар”, “нил ягаан” зэрэг өнгөнүүд цаг хугацааны явцад дан үгийн хэлбэрт шилжих, эсвэл харь хэлний үгээр нэрлэгдэх магадлалтай байдаг.

Өөрөөр хэлбэл нэг өнгөнөөс өөр бусад өнгөнүүд салан гарч (хөх ба цэнхэр,

хүрэн ба бор зэрэг нь алсдаа нэг нэг өнгө болсонтой адил ойлголт), шинэ өнгөний ай үүсгэж, үүгээрээ үндсэн өнгөний нэр өргөжиж байдаг.

Эрдэмтэн Драйвэн, Вэрспүүр нар нэг өнгөнөөс өөр нэг өнгө салж гарах хийгээд өнгөний ай үүсэх шат дарааллыг түүхэн хэл шинжлэлийн үүднээс эгшиг авианы үүсэл хөгжлийн явцтай адилтгасан (王寅著. 2018 107) нь сонирхолтой судалгаа болжээ.

“Улбар шар” өнгийг “хонгор” өнгө хэмээн нэрлэх нь бусад газрын Ойрадуудад бараг үгүй юм. Ингэж нэрлэж буйг сонсоод гайхах хүн олон байх бөгөөд “адууны өнгөөр эд юмны өнгө нэрлэх нь буруу” гэх мэтээр шүүмжлэх хандлага илэрдэг.

Сосон өнгө

Хөхнуурын Ойрадуудын дунд 47 хүнээс ягаан өнгийн зураг үзүүлэн ямар өнгө болохыг нэрлүүлэхэд 39 хүн “сосон өнгө”, 6 хүн “ягаан өнгө” 2 хүн “мэдэхгүй” хэмээн хариулсан ба нил ягаан (purple) өнгийн зургийг үзүүлэн ямар өнгө болохыг нэрлүүлэхэд 17 хүн сосон, хүрэн сосон, цэнхэр сосон, гүн сосон зэргээр хариулж, 13 хүн ягаан, 3 хүн хүрэн, 1 хүн үзмэн өнгө гээд, бусад хүмүүс мэдэхгүй хэмээн хариулжээ. Үүнээс үзэхэд “сосон” гэх өнгийг Алшаа, Шинжаан, Хөхнуур, Монгол улсын Ойрадуудын дунд ихэвчлэн хэрэглэдэг ч Хөхнуурт хамгийн их идэвхтэй хэрэглэж байна. Харин Халимагт тус үгийг хэрэглэдэггүй бөгөөд үгийн санд ч энэ үг байхгүй байна.

Эрдэмтэн Б. Бадамдорж, Г. Батзаяа нарын хэвлүүлсэн “Дөрвөд аялгууны толь”-д: “Сосан- Sosân- ягаан” (Бадамдорж, Б., Батзаяа, Г. 2016:148), эрдэмтэн Сэцэнбаатарын хэвлүүлсэн “Sinjiyang-un çaqaq aman ayalxun-u sudulul”- тольд: “Soson- (уахан)” (Сэцэнбаатар, 2017: 111) хэмээн тэмдэглэгджээ.

Өмнө нь бид монгол хэлэнд маргаз- маргас, балиуз- балиус, хулдаас- хулдааз, гэх мэтээр “з”, “с” авиа сэлгэн хэлэгддэг тул зос (н) гэх үгээс “сосон” гэх үг үүссэн байх боломжтой гэж үзэж байсан боловч, эдүгээ тус үгийн талаар өөр баримт сэлт олдож, дахин өөр өнцгөөс харах шаардлага үүсэв.

“Хорин наймт тайлбар толь”-д: “сос цэцэг- нэгэн зүйлийн цэцгийн нэр...” , “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж хэлний толь бичиг”-т “sušu- qarabtur ulayan-紫”⁴ хэмээсэн байна. Энэхүү紫 үсэг нь нил ягаан өнгийг илтгэсэн хятад үсэг билээ. Тэгэхээр манж хэлэнд мөн энэ өнгө хэрэглэгдэж байжээ.

Шинжааны Нялх Шианы Чулуунбат “Уйгар хүмүүс ийм өнгөтэй цэцгийг сосон өнгөтэй цэцэг гэнэ. Бас тийм өнгийг “чээз ран”⁵ гэж хэлдэг гэнэ” хэмээн өгүүлсэн билээ.

Мөн Шижнааны Кашкар хотын сургуулийн багш, Уйгур үндэстэн Авалжан (阿不拉江) :“сосон гэж өнгө Уйгур хэлэнд хэрэглэгдэж байна”⁶ хэмээн өгүүлэв.

Бидний үзэхээр Еврей хэлний цэцгийн нэр (lily, lotus flower, rose)-ээс үүсэлтэй

⁴ <http://hkuri.cneas.tohoku.ac.jp/project1/kdic/listAction>

⁵ Шинжааны Нялх Шианы 57 настай Чулуунбатаас 2020 оны 4 сарын 7-ны өдөр сурвалжилж тэмдэглэв.

⁶ Шижнааны Кашкар хотын сургуулийн багш, Уйгур үндэстэн Авалжан (阿不拉江)-аас 2020 оны 4 сарын 7-ны өдөр сурвалжилж тэмдэглэв.

үг байж мэднэ. Тус susan гэх үг нь Орос хэлэнд Сюзанна, хятад хэлэнд 苏珊 (Sushan), япон хэлэнд スーザン (Sūzan) гэх мэтээр маш олон хэлэнд нэвтэрсэн байна.

Үүнээс ажиглавал ягаан өнгө нь гол төлөв цэцгийн өнгөнд илэрдэг тул сосон цэцгийн өнгө нь Ойрадын аман аялгуунд өнгөний нэр болсон байна.

Зандан өнгө

Шинжааны Ойрадын 46 хүнээр нил ягаан өнгийн зургийг үзүүлэн нэрлүүлэхэд 20 хүн “зандан өнгө”, 5 хүн “уушги (оошиг) өнгө”, 8 хүн “сосон өнгө”, 3 хүн “бөөлжиргөнө өнгө”, 1 хүн “хүрэн өнгө” гээд бусад нь “мэдэхгүй” хэмээн хариулсан байна.

Үүнээс үзэхэд Монгол улсад хэлэгддэг ягаан гэх үгийг тэд мэдэхгүй бөгөөд “нил ягаан” өнгийг “ягаан” өнгөний айд багтдаг гэж бодохгүй байна. Энэ нь нэг үндэстний доторх өнгөний нэр хийгээд өнгөний ай харилцан адилгүй байж болдог гэдгийг илтгэж байна. “Ягаан” гэдэг үгийг Шинжаан, Хөхнуур, Халимаг зэрэг газар амьдарч буй ойрадууд эхэндээ мэддэггүй байснаа хожуу “хичээлийн сурах бичиг, радио, телевиз зэргээс энэ үгийг цээжилж авсан” хэмээн ярьдаг билээ.

“Зандан” гэх үгийг О. Сүхбаатар “Монгол хэлний харь үгийн толь”-д: “Дулаан оронд ургадаг анхилам үнэртэй мод. Тосоор нь үнэртэн ба эм хийнэ. Цагаан, улаан, хүрэн зандан гэж ялгана” (Сүхбаатар, 1997:111) хэмээсэн бол “Монгол хэлний их тайлбар толь”-д “халуун оронд ургадаг, зууван навчтай, анхилам үнэрт хатуу чанарын мод”⁷ хэмээн тэмдэглэжээ.

Монголчууд зандан гэх үгийг өнгөний тодотголд ашиглахдаа гол төлөв “зандан хүрэн”, “зандан улаан” гэх мэтээр улаан, хүрэн өнгөний тодотголын хэлбэрээр ашигладаг бол Шинжааны Ойрадуудын дунд Монгол улсын нэршлээр “нил ягаан” (purple) өнгийг заан нэрлэж буй нь өвөрмөц үзэгдэл юм. Шинжааны зарим хүмүүс “хар, цагаан, саарал, улаан, шар, ногоон, бор, хүрэн, хөх, цэнхэр, уушги, зандан” гэх зэргээр 12 үндсэн өнгөний айг нэрлэж байна.

Энэ нь Оросын эрдэмтэн А.П.Василевичийн тодорхойлсноор: “Үндсэн өнгө илтгэсэн үгсийн бүлэгт цагаан ба бараан ялгарааг нэрлэсэн үгс шинээр бий болно. Үүний нэг жишээ гэвэл бүх хэлд үндсэн өнгө заасан үг гэж тооцогдох улааны цайвар ялгараа болох ягаан өнгийг дурдаж болно. Славян хэлний цэнхэр өнгийг мөн оруулж болно” (Уранчимэг, 2014:47) хэмээсний нэгэн гэрч бөгөөд үндсэн өнгө заасан үгийн тоо нэмэгдэж болно гэсний баталгаа юм.

Уушги өнгө.

Шинжааны Ойрадын 46 хүнээр “ягаан” өнгийг нэрлүүлэхэд 37 хүн уушги өнгө (Ойрад аялгуунд оошиг гэнэ) 1 хүн сосон өнгө, 1 хүн ягаан өнгө, 1 хүн зандан өнгө, бусад нь мэдэхгүй хэмээн хариулсан байна.

Үүнийг нарийн ажиглавал монгол улсын утга зохиолын хэллэгээр “ягаан” хэмээн хэлдэг өнгийг голдуу “уушги өнгө”, харин “нил ягаан” өнгийг “зандан

⁷ www.mongoltoli.mn

өнгө” хэмээн ялган нэрлэж байгаа бөгөөд тэдний танихуйд энэ 2 өнгө нь өөр өөр өнгөний ай болон хөгжсөн нь тодорхой харагдаж байна. Өвөрмонголын Жарууд хошуунд мөн “ягаан” өнгийг “ийск” (уушги) хэмээн хэлдгээс үзвэл тус үг зөвхөн Ойрадуудын дунд өнгөний нэр болсон хэрэг биш, өөр бусад газар ч хэрэглэгдэж байгааг илтгэж байна.

Монголчууд малыг хүнсэнд хэрэглэхдээ эд эрхтнийх нь өнгө, бүтэц зэргийг суурин болон тариалангийн соёлтой үндэстнүүдээс хавь илүү мэддэг байжээ. Энэ танин мэдэхүйн үйл явц дээр суурилан уушгитай төстэй өнгийг нэрлэхдээ ойрад аялгуунд “оошиг өнгө” гэж нэрлэж заншжээ. “Шинжэнэ өөрд келнэ толь”-д “оошиг-розовый (о цвето); окид оошиг бүсе бүселнээ...” (Тодаева Буляш, 2001:262) хэмээн тэмдэглэсэн байна.

ОХУ-ын Халимагийн Ойрадуудын 29 хүнээс өнгө нэрлэх судалгаа авахад “уушги” өнгө, “чүүкл” өнгө, “оштв” өнгө зэрэг өвөрмөц өнгөний нэрс илэрч байна. Үүнээс “уушги” өнгө гэдэг нь бусад газрын Ойрадуудтай давхцаж байна.

Халимаг хэлний цахим корпуст тэмдэглэгдсэн үгийн сангийн дотор ягаан гэх үгийг “**Оошк** зүстэ амд, Оошк нилх махмудта, **Оошк** өңгтэ сатин, **оошк** торһн оркмж, **Оошк**, шар оркмжс зүүсн гелнгүд ” (Retrieved from http://web-corpora.net/KalmykCorpus/search/?interface_language=ru) гэх зэрэг жишээ баримт илэрч байна. “Оошк нилх” гэх үг нь “улаан нялх”, “улаан нялзрай” зэрэг үгстэй утга дүйж байна.

Оштв өнгө

Халимагийн судалгаанд оролцогчдоор улбар шар өнгийн зургийг үзүүлэн нэрлүүлэхэд 4 хүн “оштв”, 1 хүн “хоо” 6 хүн “улбар шар” 1 хүн “ангир”, 1 хүн “лууван” өнгө зэргээр харилцан адилгүй хариулсан байна. Үүнд дурдагдаж буй “хоо” гэх өнгө нь морины “хонгор” зүс бөгөөд Хөхнуурын монголчуудын “Хонгор” өнгө хэмээн нэрлэдэгтэй утга нийцэж байна.

“Оштв” гэдэг үг нь Ойрадын бусад аялгуунд байхгүй бөгөөд Орос хэлнээс зээлсэн үг ч гэж үзэх үндэс төдийлөн олдохгүй байна.

“Хальмг-Орс толь”-д: “Оштв: Оранжевый, Оштв торһн: Оранжевый шёлк, Оштв өнг: Оранжевый цвет” хэмээн тайлбарлажээ. (Мунин Бембе, 1977:407). Чухам ямар учраас ийнхүү нэрлэж байгааг цаашид үгийн гарал зүйн талаас судалж болно.

Чүүкл өнгө

Судалгаанд оролцогчдод “нил ягаан” өнгийн зургийг үзүүлэн нэрлүүлэхэд 8 хүн “Чүүкл” (зарим нь цүүкл) өнгө, 1 хүн “бэхийн өнгө”, 1 хүн цэнхэр өнгө хэмээн нэрлэж, бусад нь “мэдэхгүй байна” хэмээн хариулсан байна.

“Хальмг-Орс толь”-д: “чүүкл [чүүкел] фиолетовый: чүүкл сах: Фиолетовый альчик-биток” (Мунин Бембе, 1977:656) хэмээн тэмдэглэсэн байх бөгөөд Ойрад аялгуугаар хэлэлцдэг бусад газарт энэ үгийг хэрэглэдэггүй. Иймд тус үгийг ч үгийн гарал зүйн талаас судлах шаардлагатай байна.

Алшаагийн Ойрадууд “уушги өнгө”, “сосон өнгө” зэргийг бусад Ойрадуудын нэгэн адил хэрэглэх бөгөөд Монгол улсын Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн ойрадууд ч мөн урьд өмнө эдгээр өнгийг аман яриандаа өргөн хэрэглэж байжээ.

Дүгнэлт

Бид Монгол улсын утга зохиолын хэлний баримжаагаар монгол хэлэнд “хар, цагаан, улаан, шар, ногоон, хөх, цэнхэр, бор, хүрэн, ягаан, саарал” зэрэг нэрийг үндсэн өнгөний нэр гэж үздэг боловч нийт монгол хэлтнээ багтаан судлахад “жигэн”, “хонгор”, “оштв”, “хайлан”, “хундан”, “уушги”, “зандан”, “чүүкл”, “сосон”, “яадаан”, “пэнчин” зэрэг өвөрмөц шинжтэй өнгөний нэрс хэрэглэгдэж байгааг олж тогтоов.

Эдгээр өнгөний нэрийн дотор “жигэн”, “хонгор”, “уушги” зэрэг өнгөний нэр нь монгол хэлний уугуул үг бөгөөд “жигэн” гэх үг зөвхөн Ордосын аман аялгуунд хэлэгддэг тул хуучин үг юм.

“Улбар шар” өнгө нь шар өнгөний айд багтаж байхад Хөхнуурын Ойрадуудын дунд “хонгор өнгө”, Халимагт “оштв өнгө” хэмээн тусдаа ай үүсгэн хэлэгдэж байна. Энэ нь дэлхийн олон хэлэнд буй “оранж өнгө”-тэй дүйж байна.

Монгол улсын утга зохиолын хэлний баримжаагаар цайвар улаан өнгийг “ягаан”, “хөх, улаан” хоёр өнгөний холимог өнгийг “нил ягаан” хэмээн хэлдэг ба энэ 2 өнгө нь ерөнхийдөө “ягаан” гэх нэг өнгөний айд багтаж байхад зарим бусад монгол хэлтний дунд заримдаа хоёр өөр өнгөний айд багтаж байна. Ингэснээр зарим газар, зарим хүмүүс 11 бус 12 айгаар хэлэлцэж байна. Өнгө заасан үндсэн үгийн ай цааш нь нэмэгдвэл “юнител өнгө”, “оранж өнгө” гэх мэт харь хэлний үгээр нэрлэгдэх магадлалтай тул нутгийн аялгуунд үндсэн өнгөөр нэрлэгдэж буй үгсийг өнгө заасан үгийн хэрэглээнд идэвхтэй ашиглаж болно.

“Зандан өнгө”, “уушги өнгө”, “сосон өнгө”, “хашин өнгө”, “нил өнгө” зэрэг нь мод, цэцэг, жимс, мал амьтны биеийн эрхтэн зэргээс зүйрлэн бүтсэн өнгөний нэр байгаа бөгөөд үүнээс үүдэн өнгө заасан үгсийн гарлыг судлахдаа зүйрлэлийн аргаар бүтсэн эсэхийг нягталж үзэх хэрэгтэй гэж бид үзэж байна.

Summary of content:

The names of the main colors used in the language of a nation often have common features of the language and culture of the people. Linguistic study of names, such as color, number, and shape, is important for understanding a nation's culture, mental development, and how it recognizes things in the world.

In this article, we have studied the names of the main colors in the language of the Mongolian-speaking people today and noticed that some were pronounced differently.

The names of the main colors of the Mongolian language can be classified as “commonly pronounced primary color names” and “unique primary color names”.

Keyword: Mongolian language, name of the main color, name of the unique color

Ном зүй

- Бадамдорж, Б., Батзаяа, Г.** (2016). *Дөрвөд аялгууны толь*. Улаанбаатар: Соёмбо принтинг хэвлэл. [Badamdorj, B., Batzayaа. G. *Dörvöd ayalguunii toli*. [Dictionary of Durbut Dialect]. Ulaanbaatar: Soyombo Printing Press. 2016]
- Нандин-Эрдэнэ, О.** (2005). *Өнгө заасан нэрийг сэтгэц хэл шинжлэлийн үүднээс судлах нь. Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл*. Улаанбаатар хот [Nandin-Erdene, O. *Öngö zaasan neriig setgets hel shinjleliin үүдnees sudlah ni. Hel shinjleliin uhaanii doktorin zereg gorilson бүтeel*. [Studying names of colors from a pointview of neurolinguistic]. Thesis for the Doctor degree in Linguistics (Ph.D.). Ulaanbaatar: 2005]
- Уранчимэг, Б.** (2014). *Монгол англи хэлний өнгө илтгэсэн үг хэллэгийг когнитив хэл шинжлэлийн үүднээс зэрэгцүүлэн судлах нь. Хэл шинжлэлийн докторын зэрэг горилсон бүтээл*. Улаанбаатар хот. [Uranchimeg B. *Mongol angli helnii öngö iltgesen үг hellegiig kognitiv hel shinjleliin үүдnees zeregtсүүлэн sudlah ni. Hel shinjleliin doktoryn zereg gorilson бүтeel*. [A Comparative study on Mongolian and English color names from a pointview of cognitive linguistic]. Thesis for the Doctor degree of Linguistics. Ulaanbaatar: 2014]
- Сэцэнбаатар.** (2017). *Шинжааны цахар аман аялгууны судлал*. ӨМАХХ. [Setsenbaatar. *Shinjaanii tsahar aman ayalguunii sudlal*. [Study on the Tsakhar dialect of Xinjiang]. Inner Mongolian People's Publishing Committee: 2017]
- Мандах, Ү.** (эмх.), (1995). *Монгол И Иүй толь бичиг. Монгол тулгуур бичгийн цуврал*. Орчуулгын бүлэг (доод). ҮХХ. [Manduqu. (emkidkebe) (1995). *mongyol I үii toli bičig. Mongrol tulxur bičig- ün čubural*. orčixulx-a- yin бүлүг (dooradu). [Mongolian Yi Yi dictionary]. Mongolian reference book series. Translation group (lower). Inner Mongolian People's Publishing Committee: 1995]
- Суран, Д ба бусад.** (2012). *Соёмбо нэвтэрхий толь. Биологи*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Suran, D ba busad. (2012). *Soyombo newterhii toli. Biologi*. [Soyombo Encyclopedia. Biology]. Ulaanbaatar: Soyombo Printing: 2012]
- Намжилмаа**(эмх.), (1988). *Хорин наймт тайлбар толь*. ӨМАХХ. [Namjilma emkidkebe (1988). *Qorin naymatu tayilburi toli*. [Twenty-eighth dictionary]. Inner Mongolian People's Publishing Committee:1988]
- Норжин, Ц.** (1999 он). *Монгол хэлний толь*. ӨМАХХ. [Norjin, *Mongyol kelen-ü toli*. [Mongolian dictionary]. Inner Mongolian People's Publishing Committee:1999]
- Сүхбаатар, О.** (1997). *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар [Suhbaatar O. *Mongol helnii hari үgiin toli*. [Dictionary of loan words in the Mongolian language]. Ulaanbaatar:1997]

- Одонтор, Ш., Баттөгс, М.** (2013). *Монгол хэлний гучтын тайлбар толь*. Улаанбаатар [Odontör Sh, Battögs M. *Mongol helnii guchtiin tailbar toli*. [Mongolian dictionary of the 30]. Ulaanbaatar: 2013]
- Цэвэл, Я.** (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар [Tsewel Ya. (1966). *Mongol helnii tailbar toli*. Tsevel, Ya. [A brief explanatory dictionary of the Mongolian language]. Ulaanbaatar: 1966]
- Мунин Бембе** (1977). *Хальмг-Орос толь*. Москва [Munin bembe. *Halimg- Oros toli*. [Kalmyk-Russian dictionary]. Moscow: 1977]
- Тодаева Буляш** (2001). *Шинжэнэ өөрд келнэ толь*. Элст [Todayewa Bulyash. (2001). *Shinjainai öörd kelnai toli*. Elst. [A dictionary of the Oirat language in Xinjiang]. Elst.2001]
- Сэцэнцогт.** (1988). *Монгол үгсийн язгуурын толь*. ӨМАХХ. [Sečenčoytu. (1988). *Mongyol üges-ün ijayur- un toli*. [A dictionary of the roots of Mongolian words] Inner Mongolian People's Publishing Committee: 1988]
- Paul Kay and Chad K. McDaniel.** (1978). [*The Linguistic Significance of the Meanings of Basic Color Terms*]. Linguistic Society of America. Vol 54 No.3. 1978]
- 王寒著. (2018) 《认知语言学》, 上海外语教育出版社

Цахим холбоос

Retrieved from <http://hkuri.cneas.tohoku.ac.jp/project1/kdic/listAction>

Retrieved from http://www.putlearningfirst.com/language/research/colour_words.html

Retrieved from www.mongoltoli.mn

Retrieved from <http://web-corpora.net>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.